

Бид юуг чадах вэ?

- Аливаа зүйлийн тоо ширхэг, дэс дугаарыг заадаг тоонуудыг **натурал тоо** гэдэг.
- Бид нар натурал тоог уншиж, бичиж чадна.
- Бид бас натурал тоон дээр хийгддэг **НЭМЭХ, хасах, үржүүлэх, хуваах** үйлдлүүдийг алдаагүй хийж чаддаг.
- **Өгүүлбэртэй бодлого** бодож чадна.

Бид юуг мэдэхийг хүсэж байна?

- Ямар нэг бүтэн зүйлийг хуваахад үүссэн хэсгүүдийг тоогоор яаж бичиж болох вэ?
- Тэдгээр тоог цифр ашиглан хэрхэн тэмдэглэдэг вэ?
- Тэмдэглэсэн тоогоо хэрхэн унших вэ?
- Уг тоонууд дээр ямар үйлдлүүдийг яаж хийх вэ?




Энгийн бутархай



Зорилго

- Энгийн бутархайг таних, унших , бичих , бодох
- Математикийн шинэ нэр томъёотой танилцах
- Бие биедээ туслан хамтарч суралцах


Жишээ 1





Жишээ 1




Жишээ 1



Жишээ 1




Жишээ 1




$$= \frac{1}{4}$$

Жишээ 2



$$= \frac{5}{12}$$

Жишээ 3



$$= 3 \frac{7}{8}$$

$$\frac{1}{4}, \frac{5}{12}, 3\frac{7}{8}$$

ГЭХ МЭТ БИЧСЭН ТООГ *энгийн бутархай*
ГЭНЭ.

$$3\frac{7}{8}$$

Энгийн бутархай

3 – г **бүхэл** хэсэг

$\frac{7}{8}$ -г **бутархай** хэсэг

7 – г бутархайн **хүртвэр**

8 – г бутархайн **хуваарь** гэнэ.

Уншихдаа **гурван бүхэл наймны долоо** гэж уншина.

Дасгал 1

- Дараах бутархайнуудыг уншаарай.

$$\frac{7}{9}, \quad 6\frac{3}{8}, \quad \frac{12}{23}, \quad 8\frac{7}{10}, \quad \frac{3}{5}, \quad 12\frac{78}{125}, \quad \frac{257}{1264}$$

Дасгал 2

Үгээр бичсэн бутархайнуудыг тоогоор илэрхийлэн дэвтэртээ бичээрээ.

-Тавны гурав,





-хоёр бүхэл дөрөвний нэг,

-зургааны хоёр,

-наймны долоо

Дасгал 3.


Дараах дүрсүүдийн будагдсан өнгө тус бүрийг бутархай тоогоор илэрхийлэн бич



Дасгал 4

- Дөрөвний гурав
- Долооны зургаа
- Хоёр бүхэл аравны ес.

1. Дараах дүрсийн цэнхэрээр будагдсан хэсгийг бутархай тоогоор илэрхийлэн бич



2. Тавны гурав –г бутархайгаар илэрхийлэн бич.

3. Дараах дүрсийг таван тэнцүү хэсэгт хуваан нэг хэсгийг улаанаар буд.

Сонирхолтой бодлого

Алим хуваах

Нэг алимыг хоёр хүн тэнцүү хувааж авах болжээ.

Тэгэхдээ аль нь ч би их хэсгийг нь авсан шүү гэж сэтгэл ханамжтай байхаар яаж хуваах вэ?



Мэднэ

Мэдэхийг хүснэ

Мэдлээ